

ЗАСАГЛАЛЫН ЛЕГИТИМТ ЧАНАРЫГ ОЙЛГОХ АСУУДАЛД

А.Юндэндорж.

Монгол Улсын Их Сургуулийн Улс төр судлалын тэнхим.

Өгүүллийн товч утга: Легитимт чанар гэж юу болох, түүний гол ач холбогдол, легитимийн хэв маягийн ангилал, улс төрийн системийн легитимт шинжийн тухай өгүүлжээ.

Түлхүүр үг: Легитимность, суптанизм, Наполеон, Гитлер.

1. "Легитимность" гэдэг ойлголтын тухай

Легитимность буюу легитимт чанар гэдэг нь латины нэр томъёоны "хууль ёсны" гэсэн утгатай "Legitimes" гэсэн үгнээс гаралтай ажээ. Гэхдээ энэ нь улс төр судлалд хуулийн буюу хууль ёсны гэсэн шууд утгаар хэрэглэгддэггүй. Өөрөөр хэлбэл легитим, хууль ёс гэсэн энэхүү хоёр ойлголт хоорондоо ойролцоо боловч ижил нэр томъёо хараахан биш юм.

Легитим нь нэг талаас үнэлгээний, ёс зүйн, улс төрийн шинж чанарыг илүүтэй агуулж байхад, негөө талаас хууль зүйн хувьд хөндлөнгийн байр суурьтай байх жишээтэй. Иймээс легитимность гэдгийг "Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн байдал" гэсэн утгаар авч хэрэглэвэл илүү зохистой болов уу. Өөрөөр хэлбэл "Аль нэг улс төрийн үйл ажиллагаа, уг үйл ажиллагааг явуулагч үйл явц, учир холбогдлыг нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байдлыг легитимность гэнэ"¹.

Нийгэмд ноёрхож буй улс төрийн үзэл санаа, улс төрийн засаглалыг олон түмэн хүлээн зөвшөөрөх, тэдгээрт хүндэтгэлтэй хандах нь аль ч нийгмийн системийн динамик тэнцвэрт байдлыг нөхцөлдүүлдэг гол хүчин зүйл болдог. Гэтэл улс төрийн үзэгдлийн легитимность нь түүнд хуулиар олгогдсон хууль ёсны байдал биш юм. Тиймээс легитимность - (хүлээн зөвшөөрөгдсөн байдал) - ыг легальность-(хууль зүйт шинж)-тэй хольж хутгаж болохгүй. Хууль нь ард түмэн буюу нийгэм хүлээн зөвшөөрөхгүй байгаа засаглалыг ч хууль ёсны болгон харагдуулан, дуулгавартай дагахаас өөр аргагүй байдалд хүргэж болзошгүй. Өөрөөр хэлбэл "эрх зүйн ачаар төрийн ноёрхол нь хууль ёсны засаглалын нэр хүндийг олж авдаг"² гэхдээ засаглал нь зөвхөн хуулийн дагуу байгаад зогсохгүй олон түмнээр сайн дураар хүлээн зөвшөөрөгдөж байж засаглалаа явуулах жинхэнэ бодит хүч нөөцтэй болно.

Легитим нь улс төрийн бодлого болон засаглалыг баталгаажуулж, улс төрийн системийн тогтвортой байдлыг хангах үндэс болсон олон түмэн улс төрийн шийдвэр гаргагчдад захирагдах далдын хүчийг агуулж байдагт гол ач холбогдол нь оршино. Легитим нь засаглалд итгэх итгэл сүсгийн замаар бий болдог. Тиймээс ч өрнөдийн судлаачид төрийн засаглал зүй ёсны гэдэгт үнэмшүүлэх явдал сул байх нь улс төрийн системийн тогтвортгүй байдлын нэг үндсэн шалтгаан болдог. Ийм учраас нийгмийн төлөвшлийн тааламжтай байдлыг хангахын тулд олон түмэн шийдвэр гаргагч системийг хүлээн зөвшөөрөх, түүнд захирагдах, улмаар тэдний сонирхолд нийцэхгүй байгаа шийдвэрийг ч хүртэл хүлээн авч биелүүлэхэд хүргэдэг тийм механизмыг бий болгох хэрэгтэй гэж үздэг байна.

Чухамдаа легитимийн зарчмууд ч эцсийн дундээ цөөнх удирдаж, олонхи захирагдана гэдгийг зөвтгөдөг. Ямарваа засаглал идэвхтэй, идэвхгүй аль нэгэн хэлбэрээр хүлээн зөвшөөрөгдсөн байх нь олонтаа тохиолддог. Хэрэв ийм шинж байхгүй бол, тухайн улс төрийн систем байнгын тайван бус байдалд орж,

¹ Политология, энциклопедия. М., 1993 г

² Двулукий Янус. Введение политологии" М., 1993 г

өөрийнх нь шийдвэрийг эсэргүүцдэг хүч юм уу өрсөлдөгчөө хүчээр дарж байхаас өөр аргагүй болж, засаглалыг хэрэгжүүлэх нийгмийн үндэс суларч ирнэ.

2. Легитимиин хэв маягууд

Германы нэарт онолч судлаач М.Вебер улс төрийн ноёрхлын легитимиин онолыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулжээ. М.Вебер засаглалын легитим шинжийг засаглал юун дээр тулгуурлаж байна, засаглалын эх үүсвэр нь юу байна гэдэгт үндэслэн авч үзсэн. Тэрээр "Ноёрхол бол тодорхой тушаалд захирагдах явдлыг бий болгох боломж юм. Ноёрхол нь нэг талаас тушааж байгаа хүний тушаалд бусад хүмүүс захирагдах болно гэсэн найдлага, нөгөө талаас тушаалийг дагагчид нь тэр тушаал бол хууль ёс, шударга ёсонд нийцнэ гэсэн хоёр талын харилцан найдлагыг агуулж байдаг. Энэ хоёр найдлага байгаа цагт тушаах буюу төрийн шийдвэр жинхэнэ ёсоор биелэх болно"³ гэж үзжээ. М.Вебер цааш нь тэмдэглэхдээ: "НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ЗӨВХӨН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭН ДЭЭР ТОГТОХГҮЙ. Социаль системийн тогтворт байдлын дотоод баталгаа нь легитимт байдал юм"⁴ гэжээ.

М.Вебер улс төрийн засаглал чухам ямар хүчин зүйлүүдээр дамжуулан нийгэмд хүлээн зөвшөөрөгдөж байна гэдгээр нь буюу засаглалын эх үүсвэрээр нь "Дуулгавартай захирагдах сэдлүүд" гэдгийн үндсэн дээр засаглалын легитим шинжийн гурван хэв маягийт авч үзсэн.

Легитимиин хэв маягийн ангилал

- Уламжлалт легитим шинж
- Харизмат легитим шинж
- Хууль ёсны лигитим шинж . Эдгээр тус бүрт нь товчон авч үзье.

Уламжлалт легитим

Энэ нь эрх мэдэлд захирагдах ёс заншил, зуршил эртнээс уламжилж ирсэн дэг журам, хөдлөшгүй бат бэх байх гэсэн итгэл үнэмшилд тулгуурладаг. Энэхүү засаглалыг хэрэгжүүлэгч субъектүүдийн үйлдэл болон шийдвэрүүд уламжлал болон түүхэнд урьд өмнө тохиолдож байсан зүйлтэй нийцэж байвал хууль ёсны гэж үзнэ. Хэрвээ лидерүүд уламжлалаа зөрчвэл олон түмэн түүний легитим шинжийг зөвшөөрөхгүй. Ийнхүү засаглалын эрх баригчийн дур зоргоор аашлах явдлыг хязгаарлаж байдаг. Лидер нь уламжлалын хэм хэмжээний хүрээн дотор л дур зоргоороо шийдвэр гаргах боломжтой. Засаглал уламжлалаар, яаж хязгаарлагдаж байгаагаас хамааран уламжлалт засаглалыг хоёр ангилж үздэг. Үүнд:

1. Уламжлалаар хязгаарлагдаж, түүнтэй холбоотой байдаг засаглал
2. Уламжлалтай холбоогүй зөвхөн тухайн лидерийн шударга ёсны мэдрэхүйгээр л зохицуулдаг засаглал

М.Вебер энэ хамаарлыг цаашид гүнзгийрүүлж судлах явцдаа уламжлалт засаглалын гурван хэлбэрийг дэвшүүлж тавьсан. Тухайлбал,

a. Патриархализм. Энэ нь засаг баригч уламжлалаас бүрэн хараат байдалтай байдаг уламжлалт засаглалын цэвэр хэлбэр.

b. Патrimonialism. Засаг баригч нь уламжлалаас тодорхой хэмжээгээр чөлөөтэй байдаг. Энэ чөлөөт байдал нь байлдан эзэлсэн газар нутгаа удирдах болон захирагааны аппаратаа бүрэлдүүлж, гишүүдийг томилох байдлаар хэрэгждэг. Засаглалын аппарат ч бүрэн түүний мэдэлд байна. Мөн зэвсэгт хүчнийг тогтоон барих болон хөдөлгөх нь засаг баригчийн өөрийн нь эрх мэдлийн асуудал байдаг.

Засаг баригч удирдлагын аппаратаа хувиарлах хэрэгтэй болсон. Хэрэв аппаратын гишүүд нь нийгмийн доод давхаргаас татагдан ирсэн бөгөөд захирагааны үүрэг гүйцэтгэснийхээ төлөө хөлс авдаг бол тэдгээр нь засаг баригчийн хүсэл зоригоос хамааралтай байдаг. Ийм байдал нь засаглал

³ Weber, M. Wirtschaft and Gesellschaft. Bd 1 1964. S 162-171

⁴ М. Вебер. Иэбр. Произ. М., 1990 г. с. 640-643

төвлөрөх байдал буюу султанизмд хүргэнэ. Султанизмын үед засаглалын эрхийг өв залгамжлуулдаг бөгөөд ингэснээрээ уламжлалаас бүрэн чөлөөтэй болсон байдаг.

в.Феодализм. Ийм тогтолцоонд албан хаагчид, орон нутгийн язгууртнуудаас бүрдсэн ба удирдлагын үүрэг гүйцэтгэснийхээ төлөө хөлс авдаггүйгээрээ патримониализмаас ялгаатай багаад цаашдаа засаглал задрах явдлыг бий болгодог онцлогтой. Орон нутгийн томоохон газар нутгийг эзэмшсэн феодалууд нь төв засаглал албатуудын хооронд дамжуулагчын үүрэг гүйцэтгэдэг. Патримониализмын үед засаглал нь ганц хүний шууд мэдэлд байдаг бол феодализмын үед хууль зүйн дагуу захирагааны асуудлууд шийдвэрлэгдэнэ. Энд засаг барич болон албатуудын харилцаа гэрээний үндсэн дээр явагддаг учраас захирагааны харилцаа эрх зүйн үндсэн дагуу зохицуулагддаг гэж ойлгож болох талтай.

Уламжлалт ноёрхол нь гол төлөв хаант засаглалтай улс оронд ажиглагддаг бөгөөд ийм хэв маягийн легитим нь урт удаан хугацаанд тогтвортой оршин тогтонох чадвартай байдаг. Манай оронд ч энэ хэв маягийн легитим үйлчилж байдаг. Манай оронд ч энэ хэв маягийн легитим үйлчилж ирсэн нь эзэн хаант их түрний уламжлалаас улбаатай бөгөөд "Төрийн минь сүлд өршөө" гэж залбиран, төрөө дээдлэх явдал ердийн ухамсырын түвшинд төдийгүй албан ёсны номлолын хүрээнд ч ажиглагддаг.

Харизматик легитим

"Харизм" гэдэг нь ид шидийн хүчийг эзэмшсэн онцгой шинж чанар гэсэн утгатай грек гаралтай үг бололтой юм. Ийм засаглал ер бусын онцгой чанар, авьяас чадвар бүхий удирдагчдад тулгуурлахыг эрмэлзэдэг. Легитим байдлыг тогтоох харизматик аргыг уламлалын нэр хүндэд түшиглэх, эсвэл олонхийн хүсэл зоригийг ардчилсан замаар илэрхийлэх боломжгүй байх зэрэг нийгмийн суурь өөрчлөлтийн үед гол төлөв ашиглах явдал гардаг. Энэ тохиолдолд удирдагчийг бие хүнийх нь хувьд өргөмжлөх, нэр хүндийг нь эрх мэдлийн институттээр уламжлан бэхжүүлэх хандлага гардаг тул харизматик легитим нь удирдагч олон түмний хооронд бий болсон сэтгэл хөдлөл, хувийн харилцаанд ихэвчлэн үндэслэдэг.

Ийм учраас харизматик лидер нь түүхэн үүргээ гүйцэтгэхдээ ард олны идэвхтэй дэмжлэг, дуулгавартай байдлыг шаардана. Ийм үед лидер үйл ажиллагаагаа уламжлал болон хуулийн хэм хэмжээний дагуу бус харин өөрийн онцгой мэдрэмж, бурхнаас заясан ер бусын хүчинд тулгуурлан явуулна. Энэхүү хүчээ батлан харуулж байгаа цагт л лидерийг дагагч олон түмэн түүнд захирагдана. Харизматик засаглал нь үнэлэлт дүгнэлтээс хол зөвхөн удирдагчийн онцгой чанарт итгэх итгэл дээр тулгуурладаг учраас сайн хүмүүс төдийгүй, хоосон суржигнэгч, худал яригч, луйварчин гэх зэрэг сөрөг үйлдэлтэй хүмүүс засгийн эрх барих боломжтой болдог.

Ийм засаглал түүхийн хөгжлийн аль ч үед бий болох магадлалтайг эрдэмтэд, сэтгэгчид сээрэмжлүүлсэн байдаг билээ. Тухайлбал: Л.Сильва, Санистеван нар түүхэн баримтуудыг дурдан Ромын эзэнт улсын үеийн Юлий Цезарь, Францад Наполеон, Германы фашист удирдагч Гитлер нар харизматик лидер байсан гэж үзсэн. Харизматик тогтолцоо нь онцгой чанарыг эзэмшсэн нэг хүнд тулгуурладаг учраас байнгын байж чаддаггүй, мөн ердийн замаар засаглал дамжуулах боломжгүй байдаг. Хэрвээ удирдагч өөрийн үе залгамжлагчаа томилохгүй бол түүний хамтран зүтгэгчдийн хооронд засаглалын төлөө ширүүн тэмцэл өрнөж, улмаар тэдний нөлөө нийгэмд, алдагдахад хурдэг. Хэрэв засаг баригчийн онцгой шинж чанар түүний үр удамд дамжсан бол удам угсааны харизм болно. Харин албан тушаал болон байгууллагаар дамжсан бол институтжсэн харизм болно. Тэгсэн тохиолдолд харизм нь нийгмийн байгууллагын шинж чанартай болж бүрэлдэн тогтсон уламжлалыг дэмжих

болно. Өөреер хэлбэл засаглал нь харьцангуй уламжлалт шинж чанарт шилждэг.

Хууль ёсны легитим

Нийгэмд эрх баригчид болон албатуудын харилцаа, нийгмийн удирлагын үйл явцыг зохицуулсан, бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ бүрэлдсэн тэр л түүхийн хөгжлийн явцад хууль ёсны засаглал бий болсон. Тийм учраас түүний эх сурвалжид нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн дүрмийн дагуу буюу ардчилсан үйл явцын үр дүнд бүрдүүлсэн төрөөс гаргасан шийдвэрийг хүмүүс дагаж биелүүлэхэд түлхэц болох ухамсартай сонголт, сонирхол оршиж байдаг. Хууль ёсны засаглалын хамгийн идэвхтэй хэлбэр нь эрх баригчийн үйл ажиллагаа хуулиар хүлээн зөвшөөрөгддөгт байгаа юм.

Ийм төрийн үндсэн тулгуур нь үндсэн хууль юм. Ийм улсад хуулийг улс төрч нар гаргаж, түүний гүйцэтгэлийг бюрократ нар хэрэгжүүлнэ. Зүй зохистой төрд онцгой хувь хүнийх нь хувьд удирдагчид бус хуульд захирагдах, түүний хүрээнд эрх мэдлийн төлөөлөгчид сонгогдож ажиллана. Үр нөлөө бүхий хууль ёсны легитим нь ардчилсан төрийн үндсэн шинж болдог. Энэ нь институтжсэн легитим бөгөөд тодорхой хувь хүмүүст бус төрийн байгууламжид иргэдээс итгэх явдалд үндэслэгддэг байна.

3. Улс төрийн системийн легитимт шинж

Улс төрийн системийн үр ашигтай байдал гэдэг нь легитим шинжтэй үр ашигтай байдал гэдэг нь легитим шинжтэй салшгүй холбоотойгоор тавигдана. Улс төрийн систем үр ашигтай байвал түүний тогтворт байдал, олон түмний зүгээс үзүүлэх дэмжлэг туслалцаа, түүнд итгэх итгэл, төдийчинээ өндөр байх болно. Олон түмний туслалцаанд:

- үзэл санааны туслалцаа
- бодитой дэмжлэг туслалцаа орно.

Үзэл санааны туслалцаанд олон түмний сонгуульд оролцох нийгэмд саналаа өгөх, засаглалын үнэт зүйлийг хүлээн зөвшөөрч, дэмжиж байгаагаа илэрхийлэх г.м зүйлүүд орно. Бодитой дэмжлэг туслалцаанд засаглалын үйл ажиллагаанд олон түмэн биечлэн оролцох, биечлэн гүйцэтгэх, засаглалын үйл ажиллагаанд эдийн засгийн, санхүүгийн биетэй туслалцаа үзүүлэх (татвар төлөх, тодорхой материаллаг туслалцаа үзүүлэх) гэх мэт зүйлүүд орно. Аливаа засаглал нь эцсийн дүндээ олон түмний дэмжлэг туслалцаанд тулгуурлаж легитим шинжийг олж авахад оршино.

Тухайн улс төрин системийн легитим шинжтэй байх нэг угтвар нөхцөл нь уг систем анхнаасаа хүчирхийллийн замаар биш олон түмний сайн дурын сонголотоор бүрэлдсэн байх явдал билээ. Энэ утгаараа ард түмнээс сонгогддог ардчилсан төрүүд нь легитим шинжийг агуулдаг. Анхнаасаа зэвсэгт бослого юм уу хувьсгалт тэмцэл зэрэг хүчирхийллийн замаар бий болсон хэдий ч, бодлого үйл ажиллагаа нь олон түмний эрх ашиг, нийгмийн зорилгод нийцсэн тийм засаглал нь легитим шинжийг олж авдаг тохиолдол бий. Жишээ нь: Чили, Өмнөд Солонгос, Бразил зэрэг оронд байсан дарангуйлагч дэглэмүүд нийгмийн дэг журам ард түмнийхээ сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн эдийн засгийнхаа зөв бодлогынхоо үр дүнд легитим шинжийг олж авсан байна.

Мөн улс төрийн системийн легитим шинжийн нэг илрэл нь төр засаглалаас нийгэмд тогтоосон албан татвар болон цэргийн алба хаах гэх мэт иргэний үүргийг хүн амын олонхи нь даган биелүүлж байгаагаар илэрнэ. Ер нь хүмүүсийн сэтгэл зүйд төрийг дээдлэх үзэл гүнзгий байх тусам тухайн системийн легитим чанар өндөр байдаг. Засаглалын легитим шинж хангалттай байх тусам улс төрийн шийдвэр хэрэгжих магадлал өндөр, улс төрийн тогтворт байдал төдийчинээ баталгаатай байна. Түүнээс гадна эрс тэс, харгис үзэл багасгах магадлалтай. Улс төрийн систем нь легитим шинжтэй байхын тулд

тухайн системд засаглалыг хэрэгжүүлэгч элитүүд олон түмнээр хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Засаг баригч элитүүдийн үйл ажиллагаандаа хүч хэрэглэх явдал, түүний легитим шинжтэй урвуу хамааралтай. Өөрөөр хэлбэл легитимиин зарчмууд нийгмийн ухамсарт хир гүнзгий нэвтэрсэн байна, хүч хэрэглэх зайлшгүй байдал төдий чинээ бага байна. Нөгөө талаар хүч хэрэглэх магадлал хэдийчинээ өндөр байх тусам элитийн олон түмнээр хүлээн зөвшөөрөгдсөн байдал төдийчинээ бага байна гэсэн үг.

Үүнээс легитим шинжтэй элитүүд итгэл үнэмшил, хүндэтгэл ашигладаг, легитимт бус шинжтэй элитүүд хүчирхийлэлд тулгуурладаг гэсэн дүгнэлт хийж болно. Хүч хэрэглэх нь чухам чанартаа өөрийн үзэл бодлоо тулган хүлээлгэх явдал учраас олон түмэн хүлээж авдаггүй. Легитим нь төрийн засаглалын зайлшгүй байх шинж болох бөгөөд, түүхийн бүхий л үеийн турш засаглагч элитүүд өөрсдийгээ ямар нэгэн байдлаар хүлээн зөвшөөрөгдсөн гэж харагдуулахыг эрмэлзэж, тэдний легитим шинжийг сулруулж буй хүчин зүйлстэй илэрхий тэмцсээр ирсэн байна.

Тухайн нийгэмд нийтийн эрх ашиг, үнэт зүйлс зонхилж байвал хүн амын ихэнх хэсэг тухайн засаглалыг сайн дураар хүлээн зөвшөөрч байдаг. Гэвч легитим нь ихэнхдээ нийгмийн өмнө өөрийгөө цагаатгах гэсэн улс төрийн засаглагч субъектийн байнгын тэмцлийн явцад хэрэгжиж байдаг онцлогтой. Энд нэг зүйлийг дурдахад төрийн албан тушаалтнууд болон ард иргэдийн дунд газар сайгүй хуулийг үл тоомсорлох, зөрчих явдал түгээмэл байгаа бол улс төрийн системийн легитим шинж нь суларч байна гэсэн санаа юм. Улс төрийн системийн легитим шинж гэдэг нь уг системийг бүх нийтээр сайшааж хүлээн зөвшөөрч байгаа хэрэг огт биш. Аль ч дэглэмийн үед тухайн төр засгийн эсэргүүцэгч серөг хүчин ямар нэгэн хэмжээгээр оршиж байдаг. Харин энэхүү серөг шинж чанар бүхий хүчинүүдийг барьж байх нь улс төрийн системийн оршин тогтнолд харин ч ашигтай байдаг. Дээрх санаануудыг дүгнэх байдлаар улс төрийн системийн легитим шинжийг бүрдүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйлийг товч авч үзье.

1. Эдийн засгийн зөв бодлого чухал ач холбогдолтой. Ард түмэн юуны өмнө өөртөө бодитойгоор юу өгөв гэдгээр засаглалыг үнэлнэ. Ард түмнийхээ аж амьдралыг дээлүүлэх, материаллаг баялагын үйлдвэрлэлийг өөд нь татах, улмаар улс орныхоо эдийн засгийг хурдан тэнхрүүлэх бодлого чухал.

2. Тухайн засаглал өөрөө оршин тогтонох, улмаар нийгэмд хүсэл зорилгоо тулган хүлээлгэхийн тулд албадлага хэрэглэх шаардлага гарна. Засаглалын харилцаа юуны өмнө нийгмийн харилцаанд орж субъектийн хоорондын зөрчилт шинжийг тусгана. Энэ харилцааг засаглал гэж ойлгодог. Энэ нь ямар нэгэн хэмжээгээр албадлага байхыг шаарддаг. Зохих хэмжээний албадлага хэрэглэж чадахгүй засаглалыг легитим шинжтэй гэж хэлэхгүй. Гэхдээ албадлага гэдэг нь зөвхөн зөв бодлого гэсэн утгаар илэрхийлэгдэнэ гэдгийг мартаж болохгүй.

3. Засаглалын легитим шинжийг бүрдүүлэхийн тулд зохих хэмжээний суртал, нэвтрүүлэг чухал ач холбогдолтой. Тухайн засаглал хийж бүтээсэн зүйлээ олон түмэнд аль болох түргэн шуурхай хүргэн ойлгуулах, итгүүлэхийг эрмэлздэг. Үүний тулд мэдээлэл сурталчилгааны бүхэл бүтэн системийг бий болгосон байдаг. Гэхдээ сурталчилгаа өрөөгөл байж болохгүй. Энд засаглалын үйл ажиллагаагаас аль болох бодитой бөгөөд үнэн зөвөөр олон түмэнд хүртэх нь чухал. Иргэдийг бодит мэдээллээр байнга хангахын тулд тэдэнд төрийн үйл ажиллагааны талаар өргөн мэдээлж төр иргэний харилцан ойлголцолыг бий болгох нь засгийн легитим шинжийг хадгалахад чухал нөлөөтэй.

Өнөөдөр засаглалыг хэмжих шинэ дээд хэмжүүрийн тухай яригдах болсон ба энэ нь засаглалын легитим чанар юм. Засаглалын легитим чанарын тухай яригдснаар улс орон болгон төр засаглалаа ардчилсан, хууль ёсны байлгах, төрийн үйл ажиллагаагаа улс орныхоо төдийгүй дэлхийн улс орны хэмжээнд

хүлээн зөвшөөрүүлэх их үйлд зориулж, бодлого үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөх улс орныхоо хөгжлийг тууштай хангахад чиглүүлэх боломжтой. Засаглал легитим шинжтэй байснаар нийгэм дэх эмх замбараагүй байдал арилж, иргэдийн улс төрийн ухамсар дээшилж, улмаар эрх эрх чөлөөгөө эдлэх өргөн боломжийг олох ба бүр цаашлаад нийгмийн хөгжилд ихээхэн түлхэц болох учиртай.

Abstract: This article describes legitimate features, its significance, classification of legitimate forms and legitimate features of a political system.

Ном зүй

1. Политология. Энциклопедический словарь. М., 1993
2. Ж.Л.Кермыша, Ш.Л.Шабо. Легитимность. Политическое исследование (журнал) № 5, 1993
3. Пугачев В.П. Основы политической науки. М., 1992
4. П.К.Ганчаров, Ю.В.Ирхин, В.В.Крапиван. Начала политической науки. М., 1994
5. Улс төр судлал. УБоАкадеми. УБ., 1996
6. Р.П.Шпакова. Хөгжимноть политической власти, Вебера. Советское государство и право (журнал) № 3, 1990
7. Ю.Ялалт. Пути достажения легитимности власти в Монголии изд-во АН. УБ., 1996